

Д. Пүрэв**ШУА-ИЙН ТАЙЛАН ҮЗЭСГЭЛЭН**

1981 оны нэгдүгээр сард МҮЭ-ийн Соёлын Төв ордонд Шинжлэх Ухааны Академийн эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээс VI таван жилд шийдвэрлэсэн зарим үндсэн асуудал, улс ардын аж ахуйн материаллаг үйлдвэрлэлд нэвтрүүлсэн шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг тайлагнан дүгнэсэн том хэмжээний үзэсгэлэн гаргав.

ШУА-ийн нийгмийн ухааны хүрээлэнгүүдээс дээрх үзэсгэлэнд тавьсан зарим нэг бүтээлээс дурдвал:

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН-«БНМАУ-ын эдийн засгийн зангилгаа асуудлууд», «БНМАУ-ын нийгмийн үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх асуудлууд», «БНМАУ-ын хүн амын аж амьдралын түвшнийг цаашид дээшлүүлэх зарим асуудал», «БНМАУ социалист эдийн засгийн интеграцид» гэх мэт бүтээлүүдэд БНМАУ-ын нийгэм эдийн засгийн хөгжлийн 1990 он хүртлэх хэтийн чиглэл, үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлын ерөнхий схем зэрэг судалгаа хийжээ.

ФИЛОСОФ, СОЦИОЛОГИ, ЭРХИЙН ХҮРЭЭЛЭН-МАХН-ын XVII их хурлаас дэвшүүлсэн социалист байгуулалтын хөгжил, нийгмийн харилцааг боловсронгуй болгох, социалист аж төрөх ёсыг хэвшүүлэх, шинэ хүнийг хүмүүжүүлэх, социалист ардчилал, төрийн хууль тогтоох үйл ажиллагааг улам сайжруулах зэрэг асуудлаар философ, социоло- ги, хууль зүйн судалгаа хийжээ. Тус үзэсгэлэнд «Социалист нийгмийн харилцааг боловсронгуй болгох зарим асуудал», «БНМАУ-ын нийгмийн бүтэц», «БНМАУ дахь социалист ардчиллын хөгжил», «Социалист аж ахуйг удирдах эрх зүйн асуудал» зэрэг бүтээлүүд тавигдсан байна.

ТҮҮХИЙН ХҮРЭЭЛЭН-Өнгөрсөн таван жилд нэн эртнээс орчин үе хүртлэх, БНМАУ-ын түүхийн бүх үеэр нарийвчилсан судалгаа явуулжээ. «БНМАУ-ын түүх» нэгэн боть, «БНМАУ-ын соёлын түүх» I, II боть, «Монгол Зөвлөлтийн харилцааны түүх», «БНМАУ-ын капиталист биш хөгжлийн зам ба ажилчин анги», «БНМАУ-д социалист ахуй бүрэлдэн тогтож байгаа нь», «Төв Азийн нүүдэлчин ард түмний соёл иргэншлийн түүх» гэх зэрэг бүтээлүүд дээрх үзэсгэлэнд тавигдсан байна. Хархорин, Хархул хааны балгасаас археологчдын олсон барилгын шавар ваар урлалын сонин сайхан дурсгал, бас Төв аймгийн нутгаас олдсон морин цэргийн довтолгооноос хамгаалах төмөр зангуу зэрэг ховор олзынхоо дээжээс тавьж үзүүлсэн байна.

ДОРНОДАХИНЫ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН-Дорнодахины ард түмний түүх соёлын асуудал. Ази, Африк, Латин Америкийн хөгжиж байгаа орнуудын нийгэм эдийн засгийн хөгжлийн асуудал, капитализмыг алгасан социализм байгуулж байгаа БНМАУ-ын хөгжлийн түүхэн туршлага, олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар судалгаа явуулж «Аугаа их октябрь ба олон улсын шинэ маягийн харилцаа» (1978 он, эмхтгэл), «Гуравдахь ертөнц: эдийн засгийн тусгаар тогтнолын асуудал», 1977 он, «БНМАУ ба хөгжиж байгаа зарим орнуудын капиталист биш хөгжлийн нийтлэг ба онцлог», «БНМАУ-ын хураангуй

түүх (1949-1979)» (1980 он), «Монгол-хятадын харилцааны түүх», «БНХАУ-ын Өвөр Монголын Автономит район» (1980 он), «Маоизм ба үндэстний асуудал» эмхэтгэл (1980 он), «БНМАУ-ын түүхийг маогийнхан гуйвуулж байгааг шүүмжлэх нь» (1979 он) зэрэг бүтээл зохиол гаргасны заримыг дээрх үзэсгэлэнд тавьжээ.

ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН-Хэл зүйн байгууллын харилцаа, холбоо, орчин үеийн монгол үгсийн сан, Монголын уран зохиолын онол, түүхийн үндсэн асуудал зэрэг сэдвээр судалгаа шинжилгээний ажил явуулж «Монгол хэлний үгсийн сан», «Монгол-Орос дэлгэрэнгүй толь» I боть, «Монгол Орос нэр томъёоны толь», «БНМАУ-ын нутаг дахь түрэг бичгийн дурсгал», «Орчин цагийн монгол хэлний үг зүйн байгуулал» зэрэг бүтээл гаргаж монголын уран зохиолын онол, түүх, түүний бусад орны уран зохиолтой харилцан холбоотой болохыг судалжээ. Энэ талаар «БНМАУ-ын орчин цагийн уран зохиолын түүх» II боть, «Энэтхэг-Монголын уран зохиолын холбоо», «Төвд Монголын уран зохиолын холбоо» зэрэг зохиол гарсан байна. Эдгээр бүтээлийн дээжүүдээс уг үзэсгэлэнд тавьжээ.

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС-Эрдэм шинжилгээний мэдээллийн хөгжлийн асуудлыг авч үзсэн нэг сэдэвт зохиол, Орос монгол англи хэлний толь бичиг (мэдээллийн ажлын үгс), 16 нэр төрлийн тогтмол буюу үргэлжлэх мэдээллийн хэвлэл, Олон улсын нийгмийн ухааны мэдээллийн газартай хамтран хийсэн 20 гаруй мэдээллийн эмхэтгэл зэрэг бүтээлээ тайлан үзэсгэлэнд тавьжээ.

Үзэсгэлэнд тавигдсан ном зохиолууд нь өнгөрсөн 5 жилд нийгмийн ухааны хүрээлэнгүүдээс бичиж туурвисан дорвитой томоохон бүтээлүүдийн дээж бөгөөд тэдгээр нь эрдэм шинжилгээний ажлын үр дүнг практикт нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой юм.